

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН, ҮР АШИГ”-Т
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГАГ-2020/02-ГА

Дундговь дахь Төрийн аудитын
газрын дарга бөгөөд Тэргүүлэх
аудитор П.Төвсанаа Утас: 70592439,

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Аудитын менежер Х.Наранцацрал
Утас: 7059-2225

Аудитор Р.Хаш-Эрдэнэ Утас: 7059-
3208,

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	4
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-6
	Дүрслэлийн товч	7-8
	<u>Бүлэг А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой зөрчил байсаар байна.</u>	9-14
Дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа	А.1 Хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.	9-11
Аудитын менежер	А.2 Зураг төсөв, тооцоо судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.	12-14
Х.Наранцацрал	<u>Бүлэг Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим ТАХ-ний хэрэгжилт хангалтгүй байна.</u>	14-20
Аудитор	Б.1 Зарим ТАХ-ний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.	14-16
Р.Хаш-Эрдэнэ	Б.2 Зарим ТАХ-ний гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй байна.	16-17
Гэрээт ажилтан	Б.3 ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.	18-19
Н.Отгонбаяр	Б.4. Зарим ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.	19-20
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Дүгнэлт	20-21
	Зөвлөмж	21
	Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал	22
	Шалгагдагч байгууллагын санал тайлбар	23-25
	Тайлан баталгаажуулах тушаал	26
	Тайлангийн хавсралтууд	26-56

ХАЯГ:

*Сайнцагаан сум 7-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 214 тоот*

2020 оны 4 дүгээр сар

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТББ	Төрийн бус байгууллага
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЭДЦС	Эрдмийн далай цогцолбор сургууль
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТХДЖТ	Төв халхын дуулалт жүжгийн театр
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ГИЦС	Говийн ирээдүй цогцолбор сургууль
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ЭМТ	Эрүүл мэндийн төв

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

*Аудит хийх үндэслэл, бүрэн
эрх:*

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, “Аудитын сэдэв батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторов 2019 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан сэдвийн дагуу, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, 15.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд тус хуулийн 19.1 дэх хэсэгт зааснаар “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт:

“Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтыг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх;
- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.

*Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:*

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Барилгын тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- ✓ Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- ✓ Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”;
- ✓ Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”;
- ✓ Дундговь аймгийн 2012-2031 оны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө;

Аудитын хамарсан хүрээ:

- ✓ Дундговь аймгийн 2019 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
- ✓ Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт.

Аудитын арга зүй:

Аудитад улсын төсвөөс 2019 онд санхүүжүүлсэн, төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжин хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын 14 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитыг Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв. Аудитын арга зүйн дагуу холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, худалдан авалт, хөрөнгө оруулалт болон санхүүгийн баримт материалыг түүвэрлэн шалгах, мэдээ тайланг гаргуулж тулган баталгаажуулах, зэрэгцүүлэх, харьцуулах, ажиглалт хийх, бодит байдлыг фото зураг авч баримтжуулах зэрэг шаардлагатай горимуудыг хэрэгжүүлэн, цуглуулсан нотлох баримтад харьцуулалт, судалгаа, шинжилгээ хийж дүнг нэгтгэн боловсруулж, түүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж өглөө.

*Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:*

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн аудитын багийн аудитор Р.Хаш-Эрдэнэ, гэрээт ажилтан Н.Отгонбаяр нар 2020 оны 3 дугаар сарын 4-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд аудитыг гүйцэтгэлээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Дундговь аймгийн хэмжээнд 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 45,632.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төсөв батлагдсан байна.

Үүнээс 15,911.0 сая төгрөгийн 13 ТАХ нь эрх шилжин ирсэн, 25,955.0 сая төгрөгийн 12 ТАХ нь эрх шилжин ирээгүй байна. Эрх шилжин ирсэн ТАХ-ний хувьд 2019 онд 6,277.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Эрх шилжсэн 13 ТАХ-ээс барилга 7, зам гүүр 3, тохижилт их засварын ажил 3 байна. Сайдын багцаар авч үзвэл тайлант онд хэрэгжүүлсэн нийт ТАХ-ний 50 хувийг БСШУС-ын багц, 20 хувийг Зам, тээврийн хөгжлийн сайдын багц, 30 хувийг бусад сайдын багцаас санхүүжүүлсэн байна.

Зургийн товъёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>Зураг 1</i>	<i>Цэцэрлэгийн барилгын ашигласан хугацаа</i>	<i>11</i>
<i>Зураг 2</i>	<i>Сургуулийн барилгын ашигласан хугацаа</i>	<i>12</i>
<i>Зураг 3</i>	<i>Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар-Үүрэг даалгавар хэрэгжээгүй байдал</i>	<i>19</i>
<i>Зураг 4</i>	<i>Говийн ирээдүй цогцолбор сургуулийн спорт тоглоомын талбайн ажил</i>	<i>20</i>

График товъёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>График 1</i>	<i>Цэцэрлэгийн ачаалал</i>	<i>11</i>
<i>График 2</i>	<i>Сургуулийн хүчин чадал хэтрэлт</i>	<i>12</i>

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төсөв батлагдсанаас хойш хийлгэсэн 3 төсөл арга, хэмжээний зураг төсөл	13
Хүснэгт 2	Зураг төсөвт ороогүй, тооцоо судалгаа хийгдээгүй ажлууд	14
Хүснэгт 3	Тендер амжилтгүй болж гэрээ шууд байгуулсан төсөл, арга хэмжээ	16
Хүснэгт 4	Нэмэлт гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээ	18

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, 2012-2031 оны хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй уялдсан байдал	27-32
Хавсралт 2	Цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн тоо	33
Хавсралт 3	Сургуульд хамрагдаж буй хүүхдийн тоо	34
Хавсралт 4	Орон нутгийн хэрэгцээ шаардлагын судалгаа	35-37
Хавсралт 5	Зураг төсөлд тусгаагүй ажлын нэмэлт санхүүжилт	38
Хавсралт 6	Төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн судалгаа	39-43
Хавсралт 7	Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа	44-46
Хавсралт 8	Техникийн тодорхойлолтод заасан шаардлага, компанийн ирүүлсэн техникийн тодорхойлолтын зөрүү	47
Хавсралт 9	Төсөл, арга хэмжээний гэрээ	48-49
Хавсралт 10	Төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилт	50-51
Хавсралт 11	Эрх шилжиж ирснээс хойш үнэлгээний хороо байгуулах хүртэлх хугацаа	52



БҮЛЭГ А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой зөрчил байсаар байна.

А.1 Хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Бүх ТАХ нь 2019 оны аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нийцсэн боловч 12 ТАХ аймгийн 2012-2031 оны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй нийцээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд нийт 45,632.7 сая төгрөгийн 25 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба бүх ТАХ нь эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нийцсэн боловч 22,169.6 сая төгрөгийн 12 ТАХ нь аймгийн 2012-2031 оны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй, 2,100.0 сая төгрөгийн 1 ТАХ нь Засаг даргын мөрийн хөтөлбөртэй нийцээгүй байна. /Хавсралт №1/

Энэ нь “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.1¹, 3.6² -д заасныг тус тус зөрчиж байна.

Эдгээр асуудал нь аймгийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлогогүй, нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалт үр дүнгүй хэрэгжих, хэрэгцээ шаардлагатай асуудалд чиглэгдэхгүй байх үр дагаврыг бий болгож байна.

Иймд аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого боловсруулж, түүнд үндэслэн жил бүрийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөж байх шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг барилгын насжилт, чанар, хүртээмж, хүн ам, нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг үндэслэн урьдчилан тооцож хөрөнгө оруулалтыг эрэмбэлэн төлөвлөхгүй байна.

Аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 20 ТАХ-г хэрэгжүүлэх санал ирснийг холбогдох яамдад хүргүүлснээс 9 ТАХ батлагдаж хэрэгжүүлэхээр болсон байна.

ТАХ-г цахим системээр эрэмбэлснийг системийн ажиллагааны алдаатай байдлаас шалтгаалан холбогдох материалыг үзэх боломжгүй байлаа.

¹ /Төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэл төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, тухайн санхүүгийн жилийн төсөлд тусгахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

-Салбарын хөгжлийн бодлого, салбарын болон бүс нутгийн дунд хугацааны стратеги, мастер төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдолтой хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ байх;

-Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэр бүхий орон нутагт хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ байх;/

² Төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг нийслэлийн тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй харилцан уялдсан байхын зэрэгцээ салбарын гол тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын ач холбогдол, тухайн төслийн хэрэгжилттэй уялдуулан эрэмбэлсэн байна.

Аудитаар цэцэрлэг, сургуулийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор барилгын хүчин чадал, суралцагчдын тоо, ачааллыг судлахад:


Цэцэрлэгийн хувьд:

2019 оны жилийн эцсийн статистик тоо мэдээгээр аймгийн нийт хүн ам 46437 байна. Үүнээс 16959 буюу нийт хүн амын 36%-ийг 0-18 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байгаа юм.

Аймгийн хэмжээнд 0-5 насны нийт 6508 хүүхэд байгаа бөгөөд хүүхдийн тоо сүүлийн 10 жилийн дунджаар 2%-аар өссөн үзүүлэлттэй байна.

2019 оны байдлаар төрийн өмчийн 22 цэцэрлэгийн нийт суурилагдсан хүчин чадал 2550 хүүхэд хүлээн авах боломжтой. Харин цэцэрлэгт хамрагдахаар бүртгүүлсэн нийт хүүхдийн тоо 3243 ба цэцэрлэгүүдийн нийт ачаалал 27%-ийн хэтрэлттэй байна. /Хавсралт 2/

График 1



Тухайлбал Сайнцагаан сумын 8 цэцэрлэг 975 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай боловч цэцэрлэгт нийт 1519 хүүхэд хамрагдаж, ачаалал хэтрэлт 56% байгаа нь бусад сумдтай харьцуулахад хамгийн өндөр байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт цэцэрлэгүүдээс 50-аас дээш жил ашигласан, ашиглалтын хугацаа дууссан 2, 36-46 жил ашигласан 2, ашиглалтад ороод 21-35 жил болж байгаа 7, 11-20 жил болж байгаа 3 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа бол 10 хүртэлх жилийн ашиглалттай 11 цэцэрлэг байна. /Хавсралт 2/

Зураг 1



Үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэгийн барилгуудын 50 орчим хувь нь сүүлийн 10 жилд баригдсан, шинэ барилгууд байна. Харин Сайнцагаан сумын хувьд ачаалал хэтрэлт бусад сумдтай харьцуулахад хамгийн өндөр байгаа, 40-өөс дээш жил ашигласан, ашиглалтын хугацаа дууссан барилгын тоо олон, мөн 0-5 насны хүүхдийн тоо сүүлийн 10 жилийн дунджаар 5%-аар өссөн үзүүлэлттэй байгаа зэрэг нь Сайнцагаан суманд шинээр цэцэрлэгийн барилга барих хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Сургуулийн хувьд:

Аймгийн хэмжээнд 6-18 хүртэлх насны нийт 10451 хүүхэд байна. Үйл ажиллагаа явуулж буй 19 төрийн өмчийн сургуулийн нийт суурилагдсан хүчин чадал 8140 хүүхэд хүлээн авах боломжтой боловч 8460 хүүхэд сургуульд хамрагдсан буюу сургуулийн ачаалал 320 хүүхдээр хэтэрсэн байна.

График 2




График 2-оос харахад Дэрэн сумын сургуулийн ачаалал хэтрэлт хамгийн өндөр буюу 47%, Эрдэнэдалай сум 28%, Сайнцагаан сум 27%, Дэлгэрхангай сум 19% байхад Өлзийт -53%, Говь-Угтаал сум 45%, Луус сум 40%, бусад суманд 30%-аас дээш буюу хүчин чадлынхаа 47-72 хувийг ашиглаж байгаа нь харагдаж байна.

Сайнцагаан суманд сүүлийн 10 жилийн дунджаар 6-18 насны хүүхдийн тоо 1%-аар өссөн нь сургуулиудын ачаалал барилгын хүчин чадлаас хэтрэхэд нөлөөлсөн бол Өлзийт суманд 3%-аар буурсан үзүүлэлттэй байгаа нь тухайн сургуульд суралцах хүүхдийн тоо бага буюу барилгын хүчин чадлыг бүрэн ашиглахгүй байгаад нөлөөлсөн байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа сургуулийн барилгуудаас 50-аас дээш жил ашигласан 4, 41-50 жил ашигласан 3, ашиглалтад ороод 31-40 жил болж байгаа 5, 21-30 жил болж байгаа 3, 10 хүртэлх жилийн ашиглалттай 4 сургууль байна.

Зураг 2



Сургуулийн барилгуудын хувьд насжилт өндөр байгаа хэдий ч Дэрэн, Эрдэнэдалай, Сайнцагаан, Дэлгэрхангай сумаас бусад суманд хүчин чадалдаа хүрч ажиллаж чадахгүй байгаа нь сургуулийн барилгын хэрэгцээ шаардлага харьцангуй бага гэж дүгнэхэд хүргэж байна. /Хавсралт 3/

Иймд аймгийн хүн ам, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт болон тухайн салбарын үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, барилга, байгууламжийн чанар, насжилт, хүчин чадал зэргийг тооцон үзэж хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөж байх шаардлагатай байна.



4.2 Зураг төсөв, тооцоо судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 1

№	Төсөл, арга хэмжээний нэр	Зураг төсөл хийгдсэн он
1	Сайнцагаан сумын 150 ортой цэцэрлэгийн барилга	2019
2	Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн спорт тоглоомын талбай	2019
3	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж	2019

Тайлант онд аймагт эрх шилжиж хэрэгжүүлсэн барилга, их засвар, зам гүүрний ажлын нийт 13 ТАХ-ээс 3 ТАХ-ний зураг төслийг төсөв батлагдсанаас хойш хийлгэсэн байна. /Хүснэгт 1/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³-д заасныг зөрчсөн.

ТЭЗҮ, зураг төсөв, тооцоо судалгаа хийгдсэн ТАХ-г төсөвт тусгаж байх талаарх зөвлөмжийг ТЭЗ нарт хүргүүлэхээр ҮАГ-т уламжилж байна.

Зарим ТАХ-ний зураг төслийг боловсруулахдаа зайлшгүй шаардлагатай ажлын тоо хэмжээ, төсөвт өртгийг тусгаагүйгээс 165.5 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулан, санхүүжилт олгосон байна.

Хүснэгт 2

Шинээр баригдах 7 барилгад техникийн нөхцөл гаргуулсан боловч Сайнцагаан сумын 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын техникийн нөхцөлийг тооцоо судалгаа хийлгүй, үндэслэлгүй гаргаснаар зураг төсөлд өөрчлөлт оруулах шаардлага бий болсон.

Анх олгосон техникийн нөхцөлд үндэслэн боловсруулсан барилгын ажлын зураг төсөлд тусгагдсан дулааны шугам 50 мм голчтой байсан нь тухайн барилгыг халаах хүчин чадалд хүрэхгүй тул шугамын голчийг 76 мм болгон байршлыг өөрчлөн шугам нэмж тавьсан байна. /Хүснэгт 2/

Зураг төсөвт ороогүй, тооцоо судалгаа хийгдээгүйгээс нэмэлт ажил хийгдсэн ажлууд		
№	ТАХ-ний нэр	Нэмэлт санхүүжилт
1	Сайнцагаан сумын 150 ортой цэцэрлэгийн барилга	79.9
2	ГИЦС-ийн спорт тоглоомын талбайн тохижилт	21.6
3	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж	20.9
4	Өлзийт сумын ЭМТ-ийн их засвар	42.9
Нийт		165.5

³ /Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана./

Эдгээр өөрчлөгдсөн ажлыг гүйцэтгүүлэхээр 79.9 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан байна.

Энэ нь техникийн нөхцөл олгож буй мэргэжлийн байгууллагуудын албан тушаалтны ажлын хариуцлагагүй байдалтай холбоотой байна.

Иймд мэргэжлийн байгууллагууд техникийн нөхцөл олгохдоо барилгын норм, дүрэм стандартад нийцсэн дүгнэлт гаргаж, хариуцлагатай ажиллахад хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.



“ГИЦС-ийн спорт тоглоомын талбайн тохижилтын ажил”, “Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж”-ийн ажлын зураг төслийг “Барт төсөл” ХХК боловсруулсан бөгөөд зайлшгүй хийх шаардлагатай хөрс тэгшлэх, нягтруулах ажил, хиймэл зүлгийн резиний чигжээс хийх, явган хүний зам барих газрыг тэгшлэх шороон далангийн ажлыг төсөвт тусгаагүй орхигдуулснаас тус ажлуудыг гүйцэтгүүлэхээр 42.5 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж санхүүжилтийг олгосон байна. /Хавсралт 4/

Дээрх зөрчил нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 415 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.22⁴-т заасныг зөрчиж байна.

Тус асуудал нь зураг төсөл боловсруулахаас өмнө газрын өндөржилтийн бодит хэмжилт хийгээгүй, тооцоо судалгааг хангалтгүй хийсэнтэй холбоотой байна.

“Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж”-ийн тохижилтын ажил хийгдэх газрыг зураг төсөлд ахмадын өргөөний барилга баригдахаар төлөвлөгдсөн газарт давхцуулан тусгаснаас батлагдсан ТАХ-ний байршлыг өөрчилсөн байна.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 415 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.21⁵-т заасныг зөрчиж байна.



Өлзийт сумын ЭМТ-ийн барилгын их засварын ажлын зураг төсөлд тусгагдсан зарим ажил хийгдээгүй, ашиглагч байгууллагын саналаар зарим ажлыг өөрчлөн гүйцэтгэсэн, зураг төсөлд зарим шаардлагатай ажлыг орхигдуулсан зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.17⁶, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁷-д заасныг тус тус зөрчиж байна.

Зураг төслийг боловсруулахдаа ашиглагч байгууллагын саналыг аваагүй, бодит хэмжилт, тооцоо судалгаа хийгээгүйгээс зарим ажил орхигдох, барилгын ажил чанаргүй хийгдэх, нэмэлт төсөв шаардлагатай болох зэрэг эрсдэлийг бий болгож байна.

⁴ Хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтын дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч зарцуулах эрхгүй

⁵ Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно;

⁶ Барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулах;

⁷ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

Иймд барилгын ажлын зураг төслийг боловсруулахдаа бодит хэмжилт, тооцоо судалгаанд үндэслэн ашиглагч байгууллагын хэрэгцээ шаардлагыг тусгуулж, ТАХ-ний байрилыг аймгийн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын судалгаанд үндэслэн төлөвлөж байх талаар төсвийн байгууллагуудад зөвлөмж, чиглэл хүргүүлж, хяналт тавьж ажиллах тухай аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлээ.



БҮЛЭГ Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим ТАХ-ний хэрэгжилт хангалтгүй байна.

Б.1 Зарим ТАХ-ний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.



ТАХ-г хэрэгжүүлэх боломжтой хугацаанд эрхийг шилжүүлсэн боловч зарим ТАХ-ний зураг төсөл алдаатай хийгдсэнээс тендер шалгаруулалт зохион байгуулахад хугацаа алдсан байна.

Дундговь аймагт УТХО-аар хэрэгжих нийт 25 ТАХ-ээс 13 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжин ирсэн байна.

“Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилга”-ын ажлын эрх 2019.02.14-ний өдөр шилжин ирж, 2019.10.11-ний өдөр үнэлгээний хороо байгуулагдах хүртэл нийт 239 хоног буюу 7 сарын дараа тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

Энэ нь уг ажлын зураг төслийг 2014 онд 250 суудалтай, 1,250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй боловсруулсан боловч 2014-2019 оны барилгын материалын үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 240 суудалтай болгож өөрчилснөөр зураг төслийг шинэчлэх шаардлагатай болсон байна.

“Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж”-ийн ажлын эрх 2019.01.10-ны өдөр шилжин ирж, 2019.07.03-ны өдөр үнэлгээний хороо байгуулагдах нийт 174 хоног буюу 5 сарын дараа тендер шалгаруулалтыг зохион байгуулсан нь зураг төсөл хийлгээгүй ТАХ баталсантай холбоотой байна. /Бүлэг А.2- оос харна уу/

Эдгээр асуудал нь ТАХ хугацаандаа хэрэгжих боломжгүй болох, чанаргүй хийгдэх зэрэг эрсдэлийг бий болгож байна. /Хавсралт 7/



Техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй компанитай гэрээ байгуулсан байна.

Тайлант онд нийт 15,911.0 сая төгрөгийн 13 ТАХ-ний худалдан авах ажиллагаанд нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулж, 11 ТАХ-ний тендер шалгаруулалт амжилттай, 2 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалт амжилтгүй болсон байна.

Тухайлбал “Цагаандэлгэр сумын 240 суудалтай Соёлын төвийн барилга”-ын ажил, “Эрдэнэдалай сумын хатуу хучилттай 2 километр авто зам”-ын ажлын тендер шалгаруулалтыг 2 удаа зарласан боловч тендер шалгаруулалт амжилтгүй болж нийт 3,030.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна. /Хүснэгт 3/

Хүснэгт 3 /сая төгрөг/

Нийт төсөл арга хэмжээ		Нээлттэй тендер шалгаруулалтын арга хэрэглэсэн төсөл, арга хэмжээ				Тендер амжилтгүй болж гэрээ шууд байгуулсан төсөл, арга хэмжээ	
Тоо	Дүн	Амжилттай		Амжилтгүй		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн		
13	15,911.0	11	12,881.0	2	3,030.0	2	3,030.0

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй нийт 13 ТАХ-ээс 11 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны захиалагчаар аймгийн Засаг дарга, 2 ТАХ-ний захиалагчаар ЗДТГ ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2⁸, 45.2.2⁹, 46.1.3¹⁰-т заасныг тус тус зөрчсөн байна.

Өмнөх аудитаар тус зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж, аймгийн Засаг даргын 2019.05.17-ны А/195 тоот захирамжаар үнэлгээний хороо байгуулсан захирамжийг хүчингүй болгон, 2019.05.20-ны өдрөөс ЗДТГ үнэлгээний хороог байгуулж байхаар шийдвэрлэсэн байна.

“Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж”-ийн 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерийн баримт бичгийг боловсруулахдаа батлагдсан төсвийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зохион байгуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.21¹¹ -т заасныг зөрчиж байна.

“Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын барилгын ажил”-ын 1,200.0 сая төгрөгийн тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй “Эл Эс Би” ХХК-д, “Аймгийн төвийн хатуу хучилттай 2.8 км замын ажил”-ын 2,200.0 сая төгрөгийн тендер шалгаруулалтад техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй “Дэвших Эрдэнэ” ХХК-д тус тус гэрээ байгуулах эрх олгосон байна.

“Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж”-ийн ажлын 300.0 сая төгрөгийн тендер шалгаруулалт амжилтгүй болж, дахин тендер зарлалгүй техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй “Мандал Шилтгээн ХХК”-д гэрээ байгуулах эрх олгосон.



⁸ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад дор дурдсан этгээд захиалагч байна

⁹ аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд

¹⁰ үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах;

¹¹ Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дүгээр зүйлийн 27.1¹², 27.1.2¹³, 27.3¹⁴, 27.4¹⁵, мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1¹⁶, 30.1.1¹⁷, 30.4.1¹⁸ -т заасныг тус тус зөрчиж байна.

Дээрх зөрчил нь үнэлгээний хорооны гишүүдийн хариуцлагагүй байдалтай холбоотой бөгөөд ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хязгаарлах үр дагавартай байна.

Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан компанийг шалгаруулж байх талаар аймгийн Засаг даргад хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Гэрээ шууд байгуулахдаа ерөнхий нөхцөл, санхүүгийн чадавх, техник болон туршлагын шаардлагыг хангасан, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөлийг хамгийн сайн хангасан этгээдтэй хэлэлцээ хийж энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах, хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгаж байх шаардлагатай байна.

“Сайнцагаан сумын Наадмын талбайн барилгын дуусгалтын ажил”-ын тендер шалгаруулалтын үр дүнд 2019.07.30-ны өдөр “Зуут констракшн” ХХК –д гэрээ байгуулах эрх олгох үнэлгээний хорооны дүгнэлт гарсан боловч шийдвэрийг тендерт оролцогч “Аминхүү” ХХК-ний зүгээс Дундговь аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд аймгийн ЗДТГ болон “Зуут констракшн” ХХК-ний хооронд байгуулсан 2019.08.07-ны өдрийн БСШУСЯ/201902347 дугаартай гэрээг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргаж, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.12.17-ны өдрийн 20 тоот шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон боловч “Аминхүү ХХК” Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдлын дагуу шүүх хянан хэлэлцээд 2020.02.11-ний өдрийн 102 тоот магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

Аудитын явцад тус тендер шалгаруулалттай холбоотой баримт бичиг улсын дээд шүүхэд шалгагдаж байсан тул шалгах боломжгүй байлаа.



Б.2 Зарим ТАХ-ний гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй байна.

Эрх шилжин ирсэн 13 ТАХ-ээс 8 ТАХ нь он дамжин хэрэгжихээр, 5 ТАХ нь тайлант онд хэрэгжихээр төлөвлөгдсөн боловч 3 ТАХ-г гэрээний хугацаанд гүйцэтгэх боломжгүй болж, нэмэлт гэрээ байгуулан он дамжин хэрэгжихээр болсон байна.

¹² Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараахь шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ

¹³ техникийн тодорхойлолт/;

¹⁴ Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

¹⁵ Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана.

¹⁶ Дараахь тохиолдолд захиалагч бүх тендерээс татгалзана

¹⁷ шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй

¹⁸ тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах;

Хүснэгт 4

Нэмэлт гэрээ байгуулсан ТАХ					
Д/д	ТАХ-ний нэр	Анхны гэрээний хугацаа		Нэмэлт гэрээний хугацаа	
		Гэрээ байгуулсан огноо	Дуусах огноо	Гэрээ сунгасан огноо	Дуусах огноо
1	Сайнцагаан сумын 150 ортой 1-р цэцэрлэгийн барилга	2019.08.08	2019.12.10	2020.12.10	2020.05.29
2	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж	2019.09.23	2019.12.02	2019.12.20	2019.12.25
3	ГИЦС-ийн спорт тоглоомын талбайн тохижилт	2019.09.06	2019.10.31	2019.12.13	2019.12.18
4	Өлзийт сумын ЭМТ-ийн барилгын их засвар	2019.07.01	2019.09.01	2019.12.02	2019.12.25
5	Эрдэнэдалай сумын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт	2018.08.24	2019.05.30	2019.05.30	2019.07.10

“Сайнцагаан сумын 150 ортой 1-р цэцэрлэгийн барилга”; “Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж”, “ГИЦС-ийн спорт тоглоомын талбайн тохижилт”-ын ажлын зураг төсөл нь төсөв батлагдсанаас хойш хийгдсэн /бүлэг 1.2-оос харна уу/, зарим ажлыг тооцоо судалгаагүй төсөвлөснөөс зураг төсөлд өөрчлөлт оруулах шаардлагатай болсон зэргээс шалтгаалж гэрээний хугацааг сунгасан байна.

“Өлзийт сумын ЭМТ-ийн барилгын их засвар”-ын ажлын зураг төсөлд тусгаагүй болон ажлын тоо хэмжээ дутуу боловч зайлшгүй хийх шаардлагатай ажлуудыг гүйцэтгэхэд хугацаа шаардлагатай болсон тухай гүйцэтгэгчийн ирүүлсэн хүсэлтээр гэрээний хугацааг сунгасан байна.

Сайнцагаан сумын 150 ортой 1-р цэцэрлэгийн барилгын ажлын зураг төсөлд тусгагдсан гал тогооны өрөөнд хийх 3 тасалгаа бүхий хүнсний агуулахыг Дундговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр өрөөний зохион байгуулалтыг зураг төслөөс өөрчилсөн байна.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 415 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.21¹⁹-т заасныг зөрчиж байна. /Хүснэгт 4/

¹⁹ Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршил, солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно;

Зураг төсөл зохиогч байгууллага зураг төслийг тухайн барилга байгууламжийн зориулалт, стандарт, эрүүл ахуйд нийцүүлэн боловсруулсан эсэхэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.



Б.3 ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Тайлант онд хэрэгжүүлсэн ТАХ-нд хяналт хийж, үүрэг даалгавар өгч ажилласан боловч үр дүн хангалтгүй байна.

2019 онд хэрэгжүүлсэн 13 ТАХ-нд Газрын харилцаа, барилга хот байгуулалтын албанаас хяналт тавьж үүрэг даалгавар өгч ажилласан байна.

“Өлзийт сумын ЭМТ-ийн барилгын их засварын ажил”-ын гүйцэтгэгч компани нь тус ажлыг хүлээн авах комиссын шийдвэрээр өгсөн архивд хүлээлгэн өгөх баримтыг бүрдүүлэх, гадна цонхны ус хаялга төмөр хийх зэрэг үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй байна.

Зураг 3



Мөн ЭМТ-ийн барилгын их засварын ажлыг барилгын хувийн хэрэгт нэмж хөтлөөгүй, зарим ажлыг өөрчлөн гүйцэтгэсэн боловч гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулаагүй, бетон цутгалтын далд ажлын актыг үйлдээгүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 33.1.18²⁰, 46.1.2²¹, 46.3²², 48.5²³, 48.6²⁴, 48.7²⁵, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалаар батлагдсан барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмын 1.3²⁶ -д заасныг тус тус зөрчиж байна.

Эдгээр асуудал нь захиалагчийн хяналт хийж байгаа мэргэжлийн байгууллагын холбогдох мэргэжилтнүүдийн ажлын хариуцлагагүй байдалтай холбоотой байна.

Иймд барилгын их засварын ажлыг барилгын хувийн хэрэгт нэмж хөтлөх, архивын баримт материалыг хууль журамд заасны дагуу бүрдүүлж архивлах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

²⁰ /Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмыг батлах;/

²¹ /энэ хуулийн 33.1.18-д заасан журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх;/

²² Хөрөнгө оруулагч, захиалагч ашиглалтад оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын акт, гадна цугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын явцад захиалагч, зохиогч, улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын чанар, аюулгүй байдлын талаар гаргасан дүгнэлт, ашиглалтад оруулсан баримт бичгийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш 30 өдөрт багтаан холбогдох архивт ишлэжүүлнэ.

²³ Захиалагч энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагад барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар хүсэлт гаргах бөгөөд түүнд дараахь баримт бичгийг хавсаргана:

²⁴ Энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт, энэ хуулийн 48.5-д заасан баримт бичгийг хянаж, ажлын 10 өдрийн дотор ашиглалтад оруулах комисс ажиллуулна.

²⁵ Барилга байгууламжийг дараахь тохиолдолд ашиглалтад оруулахаас татгалзана:

²⁶ /Барилга байгууламжийн хувийн хэрэг нь тухайн барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд хийгдсэн өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэл, их засварын ажил, үзлэг шалгалт, гарсан эвдрэл, гэмтэл, согогын талаарх мэдээлэл, уг барилга байгууламжийн үндсэн үзүүлэлтийг агуулсан баримт бичиг байна./

“Эрдэнэдалай сумын цэцэрлэгт хүрээлэнгийн ажил”, “ГИЦС-ийн спорт тоглоомын талбайн ажил”-д комиссын өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлж захиалагчид хүлээлгэн өгсөн байна.

Зураг 4



“ГИЦС-ийн спорт тоглоомын талбайн ажил”

Б.4. Зарим ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.

Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж”-ийн хашааны ажил, явган хүний замын ажлын гүйцэтгэл дутуу, “Өлзийт сумын ЭМТ-ийн барилгын их засвар”-ын ажлын интернэт сүлжээ холбох, ажиглалт хяналтын системийн ажил бүрэн хийгдээгүй, галын дохиолол, кабелийн телевиз, телефон утас суурилуулах ажил болон бусад ажлыг гүйцэтгэлгүй ашиглагч байгууллагын хүсэлтээр өөр ажил гүйцэтгэсэн боловч ажлын бодит гүйцэтгэлээс 3.9 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 415 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.11²⁷, 5.1²⁸, 5.4²⁹, 5.23³⁰-д, Төсвийн тухай хуулийн 6.4.1³¹-т заасныг тус тус зөрчиж байна.

Тус зөрчил нь захиалагчийн хяналтыг хийхдээ бодит гүйцэтгэлийг зураг төсөлтэй тулгаж шалгаагүй, гүйцэтгэгч компанийн ирүүлсэн гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосонтой холбоотой байна.

Иймд барилгын их засварын ажлын гүйцэтгэлд илүү олгосон 3.9 сая төгрөгийг санхүүжилтийг гүйцэтгэгч “Одда Тайж” ХХК-аар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, хийгдээгүй дутуу

²⁷ Захиалагч барилга байгууламж, их засварын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон барилга угсралт, их засварын ажлын календарчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргаж, энэ журмын тавдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргана.

²⁸ /Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт хийж байгаа байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналт тавьж, хэмжилт шалгалтыг барилгын салбарт мөрдөж байгаа хууль болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан норм норматив, дүрэм, журмын дагуу явуулна/

²⁹ /Төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна/

³⁰ /Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шүүд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана/

³¹ /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/;

ажлыг гүйцэтгүүлж хүлээн авах, захиалагчийн хяналтыг гүйцэтгэхдээ бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгож байх талаар Засаг даргад хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд хэрэгжиж дуусах ёстой боловч гэрээний хугацааг сунган он дамжуулан хэрэгжихээр болсон ТАХ-ний үлдэгдэл санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

“Сайнцагаан сумын 150 ортой 1-р цэцэрлэгийн барилгын ажил”-ын 292.6 сая төгрөг, “Сайнцагаан сумын наадмын талбайн барилгын дуусгал ажил”-ын 552.8 сая төгрөгийг тус тус Дундговь аймгийн барьцаа хөрөнгийн дансанд, “Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламж”-ын үлдэгдэл санхүүжилт 93.9 сая төгрөгийг Зам, тээврийн яамны барьцаа хөрөнгийн дансанд тус тус байршуулсан байна.

“Говь-Угтаал сумын спорт заалны барилгын ажил”-ын 255.0 сая төгрөгийн санхүүжилтийг урьдчилгаа төлбөрийн баталгаагаар банканд байршуулсан байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ҮР ДҮН МУУТАЙ БАЙНА.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой зөрчил байсаар байна.

✓ **Хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.**

Бүх ТАХ нь 2019 оны аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нийцсэн боловч 12 ТАХ аймгийн 2012-2031 оны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй нийцээгүй байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг барилгын насжилт, чанар, хүртээмж, хүн ам, нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг үндэслэн урьдчилан тооцож хөрөнгө оруулалтыг эрэмбэлэн төлөвлөхгүй байна.

✓ **Зураг төсөв, тооцоо судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.**

Зарим ТАХ-ний зураг төслийг боловсруулахдаа зайлигүй шаардлагатай ажлын тоо хэмжээ, төсөвт өртгийг тусгаагүйгээс 165.5 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулан, санхүүжилт олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим ТАХ-ний хэрэгжилт хангалтгүй байна.

✓ **Зарим ТАХ-ний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.**

ТАХ-г хэрэгжүүлэх боломжтой хугацаанд эрхийг шилжүүлсэн боловч зарим ТАХ-ний зураг төсөл алдаатай хийгдсэнээс тендер шалгаруулалт зохион байгуулахад хугацаа алдсан байна.

Техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй компанитай гэрээ байгуулсан байна.

- ✓ *Зарим ТАХ-ний гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй байна.*
- ✓ *ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.*

Тайлант онд хэрэгжүүлсэн ТАХ-нд хяналт хийж, үүрэг даалгавар өгч ажилласан боловч үр дүн хангалтгүй байна.

- ✓ *Зарим ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.*



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. *Аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого боловсруулж, түүнд үндэслэн жил бүрийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөж байх*
2. *Аймгийн хүн ам, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт болон тухайн салбарын үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, барилга, байгууламжийн чанар, насжилт, хүчин чадал зэргийг тооцон үзэж хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөж байх*
3. *Мэргэжлийн байгууллагууд техникийн нөхцөл олгоходоо барилгын норм, дүрэм стандартад нийцсэн дүгнэлт гаргаж, хариуцлагатай ажиллахад хяналт тавьж ажиллах*
4. *Барилгын ажлын зураг төслийг боловсруулахдаа бодит хэмжилт, тооцоо судалгаанд үндэслэн ашиглагч байгууллагын хэрэгцээ шаардлагыг тусгуулж, ТАХ-ний байрилыг аймгийн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын судалгаанд үндэслэн төлөвлөж байх талаар төсвийн байгууллагуудад зөвлөмж, чиглэл хүргүүлж, хяналт тавьж ажиллах*
5. *Гэрээ шууд байгуулахдаа ерөнхий нөхцөл, санхүүгийн чадавх, техник болон туршилагын шаардлагыг хангасан, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөлийг хамгийн сайн хангасан этгээдтэй хэлэлцээ хийж энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах, хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгаж байх*

6. *Зураг төслийг тухайн барилга байгууламжийн зориулалт, стандарт, эрүүл ахуйд нийцүүлэн боловсруулсан эсэхэд хяналт тавьж ажиллах*



Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаар зураг төсөл, тооцоо судалгаа хийгдээгүй ТАХ-г төсөвт тусгаж баталсантай холбоотой зөрчил давтан гарсаар байна.

Тухайлбал 2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ❖ Зураг төслийг бодит хэмжилт, тооцоо судалгаанд үндэслэн хийгээгүй;
- ❖ Зайлшгүй хийх шаардлагатай ажлыг төсөвт тусгаагүй орхигдуулснаас 165.5 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж санхүүжилт олгосон;
- ❖ Батлагдсан ТАХ-ний байршлыг өөрчилсөн, зураг төсөлд тусгасан ажлыг өөрчлөн гүйцэтгэсэн. /Бүлэг А.2-оос дэлгэрэнгүй харна уу/


Иймд ТЕЗ нарт “ТЭЗҮ, зураг төсөв, тооцоо судалгаа хийгдсэн ТАХ-г төсөвт тусгаж байх, зураг, төслийг бодит хэмжилт, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж, зураг, төслийг боловсруулж байгаа гүйцэтгэгч компаниудын ажлын хариуцлагыг өндөржүүлэх талаар хууль, дүрэмд тусгахаар зөвлөмж хүргүүлэх” саналыг ҮАГ-т уламжилж байна.

Шалгагдагч байгууллагын санал тайлбар


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
 48000 Дундговь аймаг, Сайнцагаан сум
 Утас: 7059-2464, Факс: 7059-2866
 И-мэйл: info@dundgovi.gov.mn
 2020-04-20 № 4/303
 Төвийн _____ -ны № _____
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашгийг хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлагныг төсөлтэй танилцсан дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Зураг, төсвийг боловсруулж байгаа гүйцэтгэгч компаниуд газар дээр очиж хэмжилт хийгээгүйгээс ажлын зураг, төсөв зөрүүтэй байна. Иймд зохиогчид хариуцлагыг өндөржүүлэх талаар хууль, дүрэмд тусгах шаардлагатай байна.
2. Барилгын хөгжлийн төвөөр хянагдсан ажлын зураг, төсөв нь алдаатай баталгаажигдаж байна.
3. “Турвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын барилгын ажил”, “Сайнцагаан сумын хатуу хучилттай 2.8 км замын ажил”, “Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын дагуу тохижилт, ногоон байгууламж”-ийн ажлын тендер шалгаруулалт зохион байгуулж үнэлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.1, 27.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэн үнэлсэн.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
 БОГЛООТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
 ДАРГА  Н.ЭРДЭН-ОЧИР
 482055523
 ТУСГААР 9 9033543

Шалгагдагч байгууллагын санал тайлбар	Аудитын байгууллагын шийдвэр
1. Зураг, төсвийг боловсруулж байгаа гүйцэтгэгч компаниуд газар дээр очиж хэмжилт хийгээгүйгээс ажлын зураг, төсөв зөрүүтэй байна. Иймд зохиогчид хариуцлагыг өндөржүүлэх талаар хууль, дүрэмд тусгах шаардлагатай байна.	Үндэсний аудитын газраар дамжуулан холбогдох дээд шатны байгууллагад зөвлөмж хүргүүлэх саналыг уламжилсан.
2. Барилгын хөгжлийн төвөөр хянагдсан ажлын зураг, төсөв нь алдаатай баталгаажигдаж байна.	
3. “Турвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын барилгын ажил”, “Сайнцагаан сумын хатуу хучилттай 2.8 км замын ажил”, “Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын дагуу тохижилт, ногоон байгууламж”-ийн ажлын тендер шалгаруулалт зохион байгуулж үнэлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.1, 27.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэн үнэлсэн.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дүгээр зүйлийн 27.1, 27.1.2, 27.3, 27.4, мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.1, 30.4.1-д заасны дагуу зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн



Тайлан баталгаажуулах тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 7/12

Мөнгөн

Г

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3, Гүйцэтгэлийн аудитын журмын 12 дугаар зүйлийн 12.40-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан ГАГ-2020/02-ГА-г баталсугай.
2. Аудитаар илэрсэн зөрчлийн жишээн (акт, албан шаардлага, зөвлөмж)-ийг хавсралтаар баталсугай.
3. “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг архлгаж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д зориулсугай.
5. Аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүн 2020 оны 4 дүгээр улиралд гаргал тавилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, гүйцэтгэлийн аудитын албаны аудитор /Р.Хаш-Эрдэнэ/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ТӨВСАНАА

0000000040

Аудитаар илрүүлсэн зөрчлийн жагсаалт

Аудитын код: ГАГ-2020/02-ГА

Аудитын нэр: “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн, үр ашиг”



№	Зөрчлийн товч утга	Зөрчигдсөн хуулийн заалт	Зөрчлийн дүн сая.төг	Үүнээс				Үр өгөөжийн	
				Аудитын явцад барагдуулсан	Акт тавигдсан сая.төг	Албан шаардлага өгсөн сая.төг	Зөвлөмжөөр өгсөн сая.төг	Тоо	Мөнгөн дүн
